



2022 ОНЫ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН
ПАРАГЛАЙДИНГИЙН ЦЭГТ ГАЗАРДАХ ТӨРЛӨӨР

Улаанбаатар хот

2022 оны 11-р сарын 19-20

УДИРДАМЖ

2022 оны 11-р сарын 10-нд батлав.

Зохион байгуулагч:

МОНГОЛЫН ХАНГЛАЙДИНГ, ПАРАГЛАЙДИНГИЙН НИЙГЭМЛЭГ

Энэхүү удирдамжийг FAI-ийн Тэмцээний дүрэм (Sporting Code)-ийн

- Ерөнхий бүлэг
- Бүлэг 7: Нийтлэг зүйл
- Бүлэг 7C: Параглайдингийн цэгт газардах төрөл

зэрэг бүлгүүдийн хамгийн шинэ хувилбартай уялдуулан хэрэглэнэ.

1. Холбоо барих хаяг

И-мэйл: mhpramongolia@google.com

Утас: 91108689

Вэбсайт: <http://www.mongoliaparagliding.com/>

Facebook page: Монголын Ханглайдинг, Параглайдингийн Нийгэмлэг

2. Комиссын бүрэлдхүүн

Үйл ажиллагаа /Meet Director	Б. Энхжин	91108689	
Гарааны маршал / Launch Marshall	О. Октябрь*		*баталгаажуулах
Аюулгүй ажиллагаа/Safety Director	П. Болд	88012123	
Ерөнхий шүүгч/Chief Judge	Б. Энхтайван	89015298	
Ахлах шүүгч /Event Judge	Ч. Туул		
Цэгийн шүүгч/Target Judge	Э. Эна		
Цэгийн шүүгч/Target Judge	О. Ундрэм		
Цэгийн шүүгч/Target Judge	Б. Мөнгөнчимэг		
Цэгийн шүүгч/Target Judge	Ж. Эрдэнэзул		дадлага
Цэгийн шүүгч/Target Judge	Б. Тэмүүлэн		дадлага
Оноо бүртгэгч/Recorder	Э. Ундрэм		

3. Хөтөлбөр

Цаг	Үйл ажиллагаа	Байрлал
07:00 – 07:30	Тамирчид урьдчилсан бүртгэлээ баталгаажуулж, гарын үсэг зурах	
07:30 – 08:00	Тэмцээний дүрэм болон аюулгүй байдлын тухай сануулах яриа	
08:00 – 11:00	Тэмцээний нислэгүүд	
11:00 – 12:00	Завсарлага, тэмцээний нээлт, өдрийн хоол	
12:00 – 15:00	Тэмцээний нислэгүүд	
15:00 - 16:00	Чөлөөт нислэг	
16:00-17:00	Хаалт, шагнал гардуулах ёслол	

Хөтөлбөрт өөрчлөлт орж болно. Тэмцээн эхлэхээс өмнө оруулсан аливаа өөрчлөлтийг пэйжээр мэдээлэх болно.

4. Тэмцээнд оролцох нисэгчдийн тоо

Энэ тэмцээнд оролцох нисэгчдийн тоо хязгааргүй.

Жич: Эмэгтэйчүүдийн ангилалд 5-аас дээш тооны тамирчин бүртгүүлсэн тохиолдолд тусад нь байр эзлүүлж, шагнал өгнө.

5. Шагнал

Шагналын сангийн нийт хэмжээ – 1350000 төгрөг

Холимог ганцаарчилсан

1-байр Алтан медаль, өргөмжлөл, 400000 төг

2-байр Мөнгөн медаль, өргөмжлөл, 300000 төг

3-байр Хүрэл медаль, өргөмжлөл, 200000 төг

Эмэгтэй

1-байр Алтан медаль, өргөмжлөл, ивээн тэтгэгчийн шагнал

2-байр Мөнгөн медаль, өргөмжлөл, ивээн тэтгэгчийн шагнал

3-байр Хүрэл медаль, өргөмжлөл, ивээн тэтгэгчийн шагнал

6. Оролцогчийн хураамж

Тамирчны бүртгэлийн хураамж – 150000 төгрөг

Үүнд:

- Гэнэтийн ослын даатгал (35000 төгрөг)
- Хувийн дугаар
- Үдийн хоол
- Ус, цай, кофе
- Гарааны талбай руу очих унаа багтана.

7. Урьдчилсан бүртгэл

Тэмцээний урьдчилсан бүртгэлийг

<http://www.mongoliaparagliding.com/%D0%B1%D2%AF%D1%80%D1%82%D0%B3%D1%8D%D0%BB> холбоосоор хийлгэнэ.

8. Төлбөр хийх

Оролцогчийн хураамж болох 150000 төгрөгийг дараахь дансанд шилжүүлнэ.

Данс эзэмшигчийн нэр:	МХПНийгэмлэг
Банкны нэр:	Төрийн банк
Дансны дугаар:	38500082949

Хураамж төлөх эцсийн хугацаа: 2022 оны 11-р сарын 16-ны 12:00 цаг

Жич: Тэмцээн болохоос 5 хоногийн өмнө оролцох боломжгүйгээ мэдэгдсэн тохиолдолд төлбөрийн 50%-ийг буцааж олгоно.

9. Бүртгэл баталгаажуулах

Тэмцээний өдөр тамирчид бичиг баримтаа шалгуулан, бүртгэлийн хуудас бөглөж, гарын үсэг зурна. Мөн гарааны дарааллыг тогтоох хувийн дугаараа сугална.

10. Даатгал

Тамирчдыг гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулсан байхыг шаардана. Даатгагч нь “Бодь даатгал” компани байна. Даатгалын төлбөрийг бүртгэлийн хураамжид багтаасан байна.

11. Хэрэгсэл

Тэмцээнд хэрэглэгдэх бүх хэрэгсэл FAI-ийн Тэмцээн зохион байгуулах дүрмийн Бүлэг 7С-ийн 8-р зүйлд нийцсэн байх ёстой. Тухайлбал:

8.1.1 буюу зөвхөн EN сертификаттай далавчийг зөвшөөрнө.

8.1.3 буюу тэмцээнд бүртгүүлэхдээ тамирчид Certified Glider Certificate (Далавч баталгаажсан тухай сертификат) дээр гарын үсэг зурна.

8.3.2 буюу бүх тамирчид EN966 (HPG), EN1077-A болон –B (Snow Sports), ASTM 2040 (Snow Sports), эсвэл Snell RS-98 стандартын хамгаалалтын дуулгыг нислэгийн бүх хугацаанд өмсөнө.

8.3.3 буюу тамирчид өөрсдийн жинд тохирсон ослын ба нөөц шүхэртэй байх ёстой.

12. Хувийн дугаар

Бүлэг 7С-д заасны дагуу хувийн дугаар олгоно. 15x10 см хэмжээтэй дугаарыг тамирчин хөлөндөө бэхэлнэ.

13. Станц

Тамирчин өөрийн VHF станцтай байж болох бөгөөд өрсөлдөж буй аль нэг тамирчинд давуу тал олгохуйц мэдээлэл өгөх, дасгалжуулагчийн заавар өгөх зэрэгт хэрэглэгдэхгүй. Зөвхөн зохион байгуулагчаас Аюулгүй ажиллагааны зааварчилга өгөх зорилгоор багуудад зааж өгсөн долгион дээр тохируулсан байна. (Гэхдээ хэрэв эрсдэлтэй нөхцөл байдал үүсвэл зааварлагч багш нь туршлага багатай тамирчинд аюулгүй байдлыг нь хангуулан буулгах үүднээс заавар өгч болно).

14. Аюулгүй ажиллагааны комисс

Аюулгүй ажиллагааны комисст 3 тамирчин багтана. Тэмцээн эхлэхээс өмнө оролцох тамирчдын саналаар томилно.

15. Тэмцээн болох газар

Тухайн өдрийн цаг агаар, салхины хурд, чиглэлээс хамаарч доорх хоёр байршлын аль нэгийг сонгоно.

Байршил 1: Богдхан уул, Чулуутын ам

Координат: 47.857884, 107.089675

Гарааны өндөршил: Д.т.д

Буух талбайн өндөршил: Д.т.д

Өндрийн ялгаа: ... м

Гараанаас буух талбай хүртэлх зай: 300 м

Салхины чиглэл: Гараан дээр ..., Буух талбай дээр ...

Байршил 2: Төв аймаг, Батсүмбэр сум, Нарийний ам

Координат: 48.20194895926987, 106.61927308386339

Гарааны өндөршил: Д.т.д

Буух талбайн өндөршил: Д.т.д

Өндрийн ялгаа: ... м

Гараанаас буух талбай хүртэлх зай:

Салхины чиглэл: Гараан дээр ..., Буух талбай дээр ...

16. Гарааны тоо

Дээд тал нь 6 гараатай байна. Хамгийн бага оноо авсан нэг гарааг дүнд оруулж тооцохгүй байж болно.

Тамирчны нислэгийн сүүлчийн 30 секундын хугацаанд хэмжсэн байдлаар буух цэг дээрх салхины зөвшөөрөгдөх дээд хурд нь 6 м/с байна.

Хэрэв цаг аргаарт өөрчлөлт орж тэмцээнийг дуусгахад хүрвэл нийт гарсан гарааны оноогоор тооцох болно.

17. Сонирхогчийн видео бичлэг

Сонирхогчийн видео бичлэгийг нотлох баримт болгон ашиглаж болно.

Зохион байгуулагчид буултын видео бичлэгийг хийх үүрэг хүлээхгүй.

Албан ёсоор гомдол гаргасан тохиолдолд сонирхогчийн видео бичлэгийг нотлох баримт болгон үзэх эсэхийг шийдэх эрх нь Үйл ажиллагаа хариуцсан дарга, Ерөнхий

шүүгч хоёрт байна. Тохиолдол бүрээс хамааран ийм шийдвэрийг гаргана. Энэ талаарх нэмэлт мэдээллийг тамирчдын хурал дээр өгнө.

18. Торгууль

7С-6 бүлэгт заасны дагуу тэмцээнд оролцож буй тамирчид FAI-н Тэмцээн зохион байгуулах дүрэм болон тэмцээний удирдамжийг зөрчсөн аливаа үйлдэлд Үйл ажиллагаа хариуцсан дарга болон Ерөнхий шүүгчийн зүгээс сануулах, тухайн раундад хамгийн дээд оноо өгөх, эсвэл тэмцээнээс хасах зэргээр торгууль оногдуулж болно.

19. Гомдол, эсэргүүцэл

Шүүгчийн шийдвэртэй санал нийлэхгүй гомдол гаргавал Ерөнхий шүүгч гомдлыг шийдвэрлэнэ. Ерөнхий шүүгчийн шийдвэрийг хүлээн авахгүй, эсэргүүцэл бичих бол 100000 төгрөгийн хураамж төлнө. Хэрэв эсэргүүцэл үндэслэлтэй нь батлагдвал хураамжийг буцааж олгоно.

20. Аюулгүй байдлын асуудлууд

Түргэн тусламжийн эмч болон шаардлагатай тоноглол бүхий түргэн тусламжийн машин тэмцээний үеэр бэлэн байдалд байна. Эмнэлгийн баг газардах талбай дээр байрлана.